



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 1/2022

Мандалговь

Хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 08 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад генерал цол бий болсны түүхт 78 жилийн ойг тохиолдуулан Дундговь аймгаас төрсөн алтан мөрдөст генералуудад хүндэтгэл үзүүлэх 1 570 000 (Нэг сая таван зуун далан мянган) төгрөгийн зардал гаргасугай.

2. Зардалд шаардагдах 1570 000 (Нэг сая таван зуун далан мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100493

Аймгийн Засаг даргын 2022 оны 05  
сарын 03-ны өдрийн 40 дугаар  
захирамжийн хавсралт



ГЕНЕРАЛУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ

№	Генералууд	Бэлгийн багц	Нийт дүн
1	Жамцын Содном	Бэлэн мөнгө	500,000
2	Бямбасүрэнгийн Баярмагнай	Бэлэн мөнгө	500,000
3	Пэлжээгийн Одонбаатар	Бэлэн мөнгө, хүндэт өргөмжлөл	570,000
Нийт зардал			1,570,000